



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 27 (456)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Засгийн газрын тусгай сангийн тухай*
- *Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Хуулийн байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны долдугаар сарын 21

№27 (456)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

411.	Засгийн газрын тусгай сангийн тухай	767
412.	Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	776
413.	Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	776
414.	Монгол Улсын татварын ерөнхий хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай	776
415.	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	777
416.	Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	777
417.	Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	777
418.	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	778
419.	Гаалийн тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай	778
420.	Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	779
421.	Брайгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	779
422.	Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	779
423.	Аялал жуулчлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	780
424.	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	780
425.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай	781
426.	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	785
427.	Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай	785
428.	Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	786
429.	Зэсгийн хэлэлцээр соёрхон батлах тухай	788
430.	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	788
431.	Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	788

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

432.	Хуулийн байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай	Дугаар 54	789
433.	Төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай	Дугаар 65	790
434.	Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай	Дугаар 75	790
435.	Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 76	791
436.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 77	791

437.	Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох тухай	Дугаар 78	791
438.	Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 79	791
Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
439.	Дамбачүлтэмийн Байлхүүд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай	Дугаар 157	793
440.	Дашийн Гүрбазарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 158	793
441.	Дэмбэрэлийн Амгаланд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 159	793
442.	Дашдоржийн Цэрэнтогтоход Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 172	793
443.	Начингийн Баасанжавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 173	794
444.	Түмэнбаярын Дашцэрэнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 174	794
445.	Шагдарын Бирад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 175	794
446.	Чилхаажавын Авдайд Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай	Дугаар 176	794
447.	Бирваагийн Мөнхдоржид Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 177	795
448.	Чинзаяатын Мөнхшүрд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 178	795
449.	Батболдын Энхтүвшинд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 179	795
450.	Галсангийн Зинаамярдт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай	Дугаар 180	795
451.	Намсрайн Ням-Осорт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 181	796
452.	Жоосамбуугийн Одмаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 182	796
453.	Лувсан-Очирын Дондогт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай	Дугаар 183	796
454.	Ишцэрэнгийн Төмөрбатад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 184	796
455.	Даваажавын Даваанямд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 185	797
456.	Намсрайжавын Бүрэнбаярт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 186	797
457.	Намсрайн Дамбад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай	Дугаар 187	797
458.	Рэнчингийн Бадарчид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 188	797
459.	Жагваралын Бүрэнбэхэд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 189	798
460.	Лувсангийн Бэрэнбаралд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай	Дугаар 190	798
461.	Гочоогийн Жамцад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 191	798
462.	Даваажавын Нямсүрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 193	798



Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

463. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай

Дугаар 28

799

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай¹, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай² хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "олон улсын гэрээ" гэж Олон улсын гэрээний тухай³ хуулийн 3.1-д заасныг;

3.1.2. "төсөл хэрэгжүүлэгч" гэж Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай⁴ хуулийн 3.1.5-д заасныг.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Нийгмийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан,

Улсын авто замын сангаас бусад тусгай сантай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

4.2. Гамшгийн хор уршгийг арилгах тодорхой арга хэмжээнд зориулан гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаадын болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс Монгол Улсад өгсөн буцалтгүй тусламж, хандивыг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Засгийн газрын тусгай сан, түүний төрөл, ангилал

5 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сан, түүний төрөл

5.1. Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийн орлогыг Засгийн газрын тусгай сан / цаашид "Тусгай сан" гэх/ гэнэ.

5.2. Тусгай сангийн орлого, зарлагын тайлан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг мөн.

5.3. Тусгай санг хуулиар байгуулна.

5.4. Тусгай сан дараахь төрөлтэй байна:

5.4.1. Аялал жуулчлалын сан;

5.4.2. Байгаль хамгаалах сан;

5.4.3. Эрсдэлийн сан;

5.4.4. Бүх нийтийн үйлчилгээний

үүргийн сан;

¹ Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 26 дугаарт нийтлэгдсэн.

² Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 26 дугаарт нийтлэгдсэн.

³ Олон улсын гэрээний тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

5.4.5. Дархлаажуулалтын сан;	6.4. Энэ хуулийн 6.1.3-т заасан тусгай санд дараахь тусгай сан хамаарна:
хөгжүүлэх сан;	6.4.1. Аялал жуулчлалын сан;
5.4.6. Жижиг, дунд үйлдвэрийг	6.4.2. Байгаль хамгаалах сан;
5.4.7. Засгийн газрын нөөц сан;	6.4.3. Дархлаажуулалтын сан;
5.4.8. Мал хамгаалах сан;	6.4.4. Жижиг, дунд үйлдвэрийг
5.4.9. Монгол Улсыг хөгжүүлэх	хөгжүүлэх сан;
сан;	6.4.5. Соёл, урлаг хөгжүүлэх сан;
5.4.10. Нийгмийн даатгалын сан;	6.4.6. Сургалтын төрийн сан;
5.4.11. Нийгмийн халамжийн сан;	6.4.7. Хилийн чанадад байгаа
5.4.12. Соёл, урлаг хөгжүүлэх	Монгол Улсын иргэдэд туслах сан;
сан;	6.4.8. Хүүхдийн төлөө сан;
5.4.13. Сургалтын төрийн сан;	6.4.9. Хөрөнгө оруулалт, хөгжлийн
5.4.14. Тариаланг дэмжих сан;	сан;
5.4.15. Улсын авто замын сан;	6.4.10. Шинжлэх ухаан,
5.4.16. Хилийн чанадад байгаа	технологийн сан;
Монгол Улсын иргэдэд туслах сан;	6.4.11. Эрүүл мэндийг дэмжих
5.4.17. Хүүхдийн төлөө сан;	сан;
5.4.18. Хөдөлмөр эрхлэлтийг	
дэмжих сан;	6.5. Энэ хуулийн 6.1.4-т заасан тусгай санд дараахь тусгай сан хамаарна:
5.4.19. Хөрөнгө оруулалт,	6.5.1. Бүх нийтийн үйлчилгээний
хөгжлийн сан;	үүргийн сан;
5.4.20. Шинжлэх ухаан,	6.5.2. Мал хамгаалах сан;
технологийн сан;	6.5.3. Тариаланг дэмжих сан;
5.4.21. Эрүүл мэндийг дэмжих	6.5.4. олон улсын гэрээний дагуу
сан;	байгуулагдсан сан.
5.4.22. олон улсын гэрээний дагуу	
улсын төсвийн хөрөнгө, гадаад улс, олон улсын	6.6. Энэ хуулийн 6.5-д заасан тусгай сан үйл
байгууллага, түүнчлэн гадаад улсын бусад	ажиллагаагаа өөрөө өөрийгөө санхүүжүүлэх
байгууллагаас олгосон буцалтгүй тусламж,	зарчмаар явуулна.
хандиваас бүрдүүлэх сан /цаашид "олон улсын	
гэрээний дагуу байгуулагдсан сан" гэх/.	

6 дугаар зүйл. Тусгай сангийн ангилал

- 6.1. Тусгай санг дараахь ангилалд хуваана:
- 6.1.1. тусгай хуулиар зохицуулах сан;
- 6.1.2. эх үүсвэрийг нь 100 хувь төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сан;
- 6.1.3. эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сан;
- 6.1.4. эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг буцалтгүй тусламж, хандиваар бүрдүүлэх сан.
- 6.2. Энэ хуулийн 6.1.1-д заасан тусгай санд дараахь тусгай сан хамаарна:
- 6.2.1. Нийгмийн даатгалын сан;
- 6.2.2. Нийгмийн халамжийн сан;
- 6.2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;
- 6.2.4. Улсын авто замын сан.
- 6.3. Энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай санд дараахь тусгай сан хамаарна:
- 6.3.1. Засгийн газрын нөөц сан;
- 6.3.2. Монгол Улсыг хөгжүүлэх сан;
- 6.3.3. Эрсдэлийн сан.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тусгай санг бүрдүүлэх, зарцуулах

7 дугаар зүйл. Тусгай санг бүрдүүлэх нийтлэг эх үүсвэр

- 7.1. Энэ хуулийн 6.1.3-т заасан тусгай сан нь дараахь нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ:
- 7.1.1. улсын төсвийн хөрөнгө;
- 7.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;
- 7.1.3. гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээл.
- 7.2. Энэ хуулийн 6.1.4-т заасан тусгай сан нь дараахь нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ:
- 7.2.1. хууль, олон улсын гэрээнд заасны дагуу улсын төсвөөс олгох хөрөнгө;
- 7.2.2. гадаадын тусламжийн мөнгөн хөрөнгө, тоног төхөөрөмж, бараа материал, бусад эд зүйл;
- 7.2.3. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн

нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;

7.2.4. тусгай сангийн үйл ажиллагаанаас олсон орлого;

7.2.5. бусад эх үүсвэр.

8 дугаар зүйл. Засгийн газрын нөөц сан

8.1. Төсвийн ерөнхийлөн захирагч энэ хуулийн 8.3-т заасан зориулалтаар өмнөх онд гарсан зардлын гүйцэтгэл, байгаль, цаг уурын болзошгүй өөрчлөлтийн талаархи судалгаа, урьдчилсан таамаглал, экспорт, импортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнийн хэлбэлзэл, цаашдын төлөв, төсвийн орлогын боломж, чадавхийг харгалзан тухайн жилд улсын төсвөөс нөөц санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

8.2. Засгийн газрын нөөц сан болон Эрсдэлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ нь тухайн төсвийн жилд төлөвлөгдөж байгаа дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хүртэл хувьтай тэнцүү байна.

8.3. Тухайн жилийн төсөвт урьдчилан төлөвлөж тусгах боломжгүй дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд энэ хуулийн 8.1-д заасан сангийн хөрөнгийг зарцуулна:

8.3.1. хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;

8.3.2. үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах;

8.3.3. алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирсан хохирлыг арилгах;

8.3.4. төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардал;

8.3.5. Засгийн газар олон улсын шүүх, арбитраг хариуцагчаар татагдсан буюу тэдгээрээс гарсан шийдвэрийг биелүүлэхэд шаардагдах зардал;

8.3.6. олон улсын гэрээний дагуу Монгол Улс төлөх, тухайн жилийн төсөвт тусгагдаагүй татвар, төлбөр, хураамж;

8.3.7. байгууллага, иргэдээс тавьсан хүсэлт болон цаг үеийн шинжтэй зарим асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах зардал.

8.4. Гамшгийн хор уршгийг арилгахад зориулан гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын байгууллага, иргэн, хуулийн этгээдээс өгсөн буцалтгүй тусламж, хандивын хөрөнгийг тухайн зориулалтаар нь зарцуулах бөгөөд уг хөрөнгө нь хүрэлцэхгүй бол Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлнэ.

9 дүгээр зүйл. Монгол Улсыг хөгжүүлэх сан

9.1. Монгол Улсыг хөгжүүлэх сан нь Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай¹ хуулийн дагуу улсын төсөвт орох орлогоос бүрдэнэ.

9.2. Энэ хуулийн 9.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

9.2.1. давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн төсвийн орлогын дутагдлыг нөхөх;

9.2.2. улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, жижиг, дунд бизнес /аж ахуйн үйл ажиллагаа/-ийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт;

9.2.3. хүүхэд, гэр бүлийг дэмжих.

9.3. Энэ хуулийн 9.1-д заасан сангийн хөрөнгийг мөн хуулийн 9.2-т заасан арга хэмжээ тус бүрт гуравны нэгээр хуваарилна.

10 дугаар зүйл. Эрсдэлийн сан

10.1. Дор дурдсан нөхцөл, байдал үүссэний улмаас төсвийн орлого их хэмжээгээр тасалдах буюу зарлага мөн хэмжээгээр нэмэгдэх тохиолдолд Эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулна:

10.1.1. гамшгийн улмаас хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспорт хязгаарлагдах;

10.1.2. олон улсын санхүүгийн зах зээлд чөлөөт валютын ханш огцом өөрчлөгдөх;

10.1.3. гамшиг болон урьдчилан тооцох боломжгүй бусад нөхцөл, байдал үүссэний улмаас дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурах.

¹ Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

11 дүгээр зүйл. Аялал жуулчлалын сан

11.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилд Засгийн газраас аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг харгалзан Аялал жуулчлалын санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

11.2. Энэ хуулийн 11.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

11.2.1. эх орны байгалийн үзэсгэлэнт газар, үндэсний соёл, хүн ардын зан заншил, түүхийг сурталчилсан кино, дүрс болон дууны бичлэг хийх, нэм, ил захидал, танилцуулга, цомог хэвлэх, мэргэжлийн сонин, сэтгүүл гаргах, улсын болон олон улсын чанартай хурал, зөвлөлгөөн, дотоод, гадаадын үзэсгэлэн, яармаг зохион байгуулах;

11.2.2. аялал жуулчлалын дэд бүтэц байгуулах төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

11.2.3. аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, байгаль орчныг хамгаалах;

11.2.4. байгаль, түүх, соёлын өвийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах.

12 дугаар зүйл. Байгаль хамгаалах сан

12.1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

12.1.1. тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж;

12.1.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай¹ хуулийн 4.2 дахь хэсэгт заасан мөнгөн хөрөнгө.

12.2. Энэ хуулийн 12.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

12.2.1. байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал, өөрчлөлтийн байдлыг судлан тогтоох, мэдээллийг хуримтлуулж болсвруулах, дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээ;

12.2.2. байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн

сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах;

12.2.3. байгаль орчныг хамгаалахтай холбогдсон асуудлаар үндэсний болон олон улсын семинар, онол, практикийн бага хурал, уулзалт, симпозиум зэрэг арга хэмжээг зохион байгуулах;

12.2.4. байгаль орчныг хамгаалах, хянах, судлахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэмжих багаж худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

12.2.5. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сурталчлах, шинэчлэн судлах үйл хэрэгт онцгой амжилт гаргасан өөрийн улсын болон гадаадын иргэдийг шагнах;

12.2.6. байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

12.2.7. байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаа явуулах;

12.2.8. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн² 36.2-т заасан экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дэмжих.

13 дугаар зүйл. Дархлаажуулалтын сан

13.1. Дархлаажуулалтын сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д заасан болон сайн дурын дархлаажуулалтын төлбөрийн орлогоос бүрдэнэ.

13.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилд дархлаажуулалтын арга хэмжээнд шаардагдах зардлыг харгалзан уг санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

13.3. Энэ хуулийн 13.1-д заасан дархлаажуулалтын төлбөрийн хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

13.4. Энэ хуулийн 13.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

13.4.1. урьдчилан сэргийлэх тарилга хийх;

13.4.2. дархлаажуулалтын зориулалтаар урьдчилан сэргийлэх тарилга хийх, эм, бэлдмэл, зүү, тариур бэлтгэх зэрэг үйл ажиллагаа явуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

¹ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2000 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

² Байгаль орчныг хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.

14 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

14.1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

14.1.1. тусгай сангийн үйл ажиллагаанаас олсон орлого;

14.1.2. олгосон зээлийн буцаан төлөлтийн орлого;

14.1.3. бусад орлого.

14.2. Энэ хуулийн 14.1-д заасан сангийн хөрөнгийг дараахь арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

14.2.1. ажлын байр бий болгох;

14.2.2. жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд зориулж зээл олгох.

15 дугаар зүйл. Соёл, урлаг хөгжүүлэх сан

15.1. Соёл, урлаг хөгжүүлэх сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

15.1.1. соёл, урлаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр зохион байгуулсан урлагийн тоглолт, уран бүтээлийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн үзэсгэлэнгийн орлого;

15.1.2. гадаад улсад зохион байгуулсан урлагийн тоглолт, уран бүтээлийн болон түүх соёлын дурсгалт зүйлийн үзэсгэлэн, тэдгээртэй адилтгах арга хэмжээнээс олсон орлого.

15.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь соёлыг хөгжүүлэх, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг харгалзан энэ хуулийн 15.1-д заасан санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

15.3. Энэ хуулийн 15.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

15.3.1. соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах;

15.3.2. урлаг, утга зохиолын шинэ уран бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

15.3.3. төсвийн хөрөнгөөр бүтээх уран сайхны болон баримтат кино, үндэсний уламжлалт бөгөөд сонгодог урлагийн бүтээл туурвих;

15.3.4. соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйл, үндэсний соёл, урлагийг гадаадад болон өөрийн оронд сурталчилсан кино, дуу авианы бичлэг хийх, ном хэвлүүлэх, соёл, урлагийн

мэргэжлийн сонин, сэтгүүл гаргахад дэмжлэг үзүүлэх;

15.3.5. соёл, урлагийн тоглолт хийх, түүх, соёлын дурсгалт зүйл, уран бүтээлийн үзэсгэлэнг гадаадад болон өөрийн оронд зохион байгуулах;

15.3.6. хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгох уран бүтээл туурвих, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах;

15.3.7. соёл, урлагийн байгууллагад онцгой шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал худалдан авах;

15.3.8. соёл, урлагийн ажилтан, уран бүтээлчдийн мэргэшил дээшлүүлэх сургалт-семинар зохион байгуулах, тэдгээрийг гадаад, дотоодод зохиогдох соёл, урлагийн арга хэмжээ, тэмцээнд оролцуулах;

15.3.9. хөгжмийн том хэмжээний болон дүрслэх урлаг, кино, ном хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах;

15.3.10. олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, тэмцээн, үзэсгэлэн, номын яармагт оролцож онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдийг шагнаж урамшуулах;

15.3.11. үндэсний соёл, урлагийг хөгжүүлэх, соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалахад хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг алдаршуулах.

16 дугаар зүйл. Сургалтын төрийн сан

16.1. Сургалтын төрийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

16.1.1. сургалтын зориулалттай зээлийн төлбөр;

16.1.2. буцалтгүй тусламжийг давхардуулан олгосон зөрчлийг арилгахтай холбогдсон болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

16.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилд сургалтын зээл, буцалтгүй тусламж, үнэ төлбөргүй сургалтад хамрагдах суралцагсдын тоо, сургалтын төлбөрийн жишиг хэмжээг харгалзан энэ хуулийн 16.1-д заасан санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

16.3. Энэ хуулийн 16.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

16.3.1. сургалтын төлбөрийн зээл олгох;

16.3.2. сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж үзүүлэх;

16.3.3. сургалтын төлбөрийг төрөөс хариуцан үнэ төлбөргүй сургах.

16.4. Сургалтын төрийн сангийн хөрөнгийг зарцуулах журмыг Засгийн газар батална.

17 дугаар зүйл. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан

17.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг урьд онд тухайн санд орсон орлого болон гарсан зардлын гүйцэтгэл, жилийн эцсийн үлдэгдлийг харгалзан төлөвлөнө.

17.2. Энэ хуулийн 17.1-д заасан сангийн хөрөнгийг хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдэнд эд материал, санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

18 дугаар зүйл. Хүүхдийн төлөө сан

18.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Хүүхдийн төлөө санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг тухайн жилд Засгийн газраас хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг харгалзан төлөвлөнө.

18.2. Энэ хуулийн 18.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

18.2.1. хүүхдийн хөгжил, хамгааллын бодлого, чиглэлд нийцсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

18.2.2. хүүхдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах зорилгоор зарим онцгой нөхцөлд тусламж үзүүлэх;

18.2.3. хүүхэд, өсвөр үеийнхний гишүүнчлэлтэй төрийн бус байгууллагын зарим үйл ажиллагааг дэмжих.

19 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан

19.1. Энэ хуулийн 6.4.9-д заасан Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгийг дараахь арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

19.1.1. зээл олгох, зээлийн баталгаа гаргах;

19.1.2. бизнес /аж ахуйн үйл ажиллагаа/ эрхлэхтэй холбогдсон зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

19.1.3. гадаад зах зээлд гарахад тусалцаж үзүүлэх;

19.1.4. өндөр технологи нутагшуулах;

19.1.5. бизнес инкубатор байгуулах.

20 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн сан

20.1. Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д заасан эх үүсвэр болон тухайн сан өөрийн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэнэ.

20.2. Энэ хуулийн 20.1-д заасан санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1.5 хувиас багагүй байна.

20.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилд Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төсөл болон онолын суурь судалгааны зардлыг харгалзан улсын төсвөөс энэ хуулийн 20.1-д заасан санд олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

20.4. Энэ хуулийн 20.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

20.4.1. шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа хийх;

20.4.2. Засгийн газрын /улсын/ захиалгатай шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх;

20.4.3. эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх.

21 дүгээр зүйл. Эрүүл мэндийг дэмжих сан

21.1. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д заасан эх үүсвэр болон тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөс бүрдэнэ.

21.2. Энэ хуулийн 21.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

21.2.1. тамхи, архины хяналт, эрүүл мэндийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

21.2.2. тамхи, архинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх болон хүн амын эрүүл мэндийг хамгаалах бусад үйл ажиллагааг дэмжих;

21.2.3. тамхи, архины хор хөнөөлтэй тэмцэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах, хяналт тавих;

21.2.4. тамхи, архинаас гаргах эмчилгээ, түүнд шаардлагатай эм, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх;

21.2.5. тамхи, архины хэрэглээнээс хүн амын эрүүл мэнд, эдийн засагт учрах хор холбогдлыг судлах;

21.2.6. архи́нд донтох өвчтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээг боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх;

21.2.7. архидан согуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй оролцож үр дүнд хүрсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагааг дэмжих.

22 дугаар зүйл. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан

22.1.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

22.1.1. энэ хуулийн 7.2-т заасан эх үүсвэр;

22.1.2. харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгө.

22.2.Энэ хуулийн 22.1.2-т зааснаар төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь тухайн этгээдийн албан татвар ногдуулах орлогын 2 хувьтай тэнцүү байна.

22.3.Энэ хуулийн 22.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

22.3.1. зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх;

22.3.2. харилцаа холбооны сүлжээ шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх.

23 дугаар зүйл. Мал хамгаалах сан

23.1.Энэ хуулийн 6.5.2-т заасан Мал хамгаалах сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

23.1. бэлчээрийн даацыг тодорхойлох, мал оторлон өвөлжүүлэхтэй холбогдсон судалгаа явуулах;

23.2. хадлан, тэжээл бэлтгэх зориулалттай техник, технологийн шинэчлэлт хийх;

23.3. худаг сэргээн засварлах, уст цэг шинээр гаргах;

23.4. тусгай сангийн үйл ажиллагаатай холбогдсон зардлыг нөхөх.

24 дүгээр зүйл. Тариаланг дэмжих сан

24.1.Энэ хуулийн 6.5.3-т заасан Тариаланг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

24.1.1. усалгаатай тариаланг хөгжүүлэх, усалтын систем байгуулах, сэргээн засварлах;

24.1.2. тариалангийн газрыг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах;

24.1.3. таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх;

24.1.4. хөдөө аж ахуйн техник, технологийн шинэчлэлт хийх;

24.1.5. тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс стандартын шаардлага хангасан буудай худалдан авах;

24.1.6. тусгай сангийн үндсэн хөрөнгөд засвар үйлчилгээ хийх.

25 дугаар зүйл. Олон улсын гэрээний дагуу байгуулагдсан сан

25.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь олон улсын гэрээний дагуу байгуулагдсан санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг үйл ажиллагаа явуулж байгаа сангуудын урьд оны орлогын гүйцэтгэл, тухайн төсвийн жилд эдгээр санд төвлөрөх буцалтгүй тусламж, хандивыг харгалзан төлөвлөнө.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

25.2.1. тухайн гэрээнд заасан төсөл, хөтөлбөр, арга хэмжээ;

25.2.2. гадаад улс, түүнчлэн олон улсын болон гадаад улсын байгууллагатай тохиролцсон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ.

26 дугаар зүйл. Тусгай сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргах

26.1.Төсвийн ерөнхийлөн захирагчдаас энэ хуульд заасны дагуу тусгай санд төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасан журмын дагуу хянаж, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын төсвийн төсөлд тусгана.

26.2.Энэ хуулийн 6.3-т заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг Засгийн газар гаргана.

26.3.Энэ хуулийн 6.4-т заасан тусгай сангийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг Засгийн газар тогтоох бөгөөд хөрөнгийг нь захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

26.4.Энэ хуулийн 6.5-д заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийг тухай бүр Засгийн газар тогтоох бөгөөд Засгийн газраас эрх олгосон этгээд нь төсөл хэрэгжүүлэгч байна.

26.5.Энэ хуулийн 4.2-т заасан хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг онцгой байдлын

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

26.6 Энэ хуулийн 5.4.9-д заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, 5.4.3, 5.4.19-д заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмыг Засгийн газар тус тус батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Тусгай сангаас санхүүжилт олгох журам

27 дугаар зүйл. Тусгай сангийн байршил

27.1. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5.4.16-д зааснаас бусад тусгай сангийн хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулна.

27.2. Энэ хуулийн 27.1-д заасан дансанд байршиж байгаа мөн хуулийн 6.5-д заасан тусгай сангийн хөрөнгийн үлдэгдэлд хүү олгоно.

28 дугаар зүйл. Тусгай сангаас санхүүжилт хийх хэлбэр

28.1. Тусгай сангийн санхүүжилтийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасан журмын дагуу хийнэ.

28.2. Засгийн газрын нөөц сангаас дараах хэлбэрээр санхүүжилт олгоно:

28.2.1. урьдчилгаа олгож гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу тухайн ажил, үйлчилгээний онцлог, шаардагдах хөрөнгийн хэмжээтэй уялдуулан үе шаттайгаар санхүүжүүлэх;

28.2.2. шууд санхүүжүүлэх буюу ажил, үйлчилгээг гүйцэтгэсний дараа санхүүжилтийг бүрэн хэмжээгээр нэг удаа олгох.

28.3. Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, гүйцэтгэх ажил, үйлчилгээний онцлог, зарцуулах хөрөнгийн хэмжээг харгалзан санхүүжилтийн хэлбэрийг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

29 дүгээр зүйл. Төрийн сангаас санхүүжилт олгох журам

29.1. Төрийн сангийн газар энэ хуулийн 27.1-д заасны дагуу тусгай дансанд байршуулсан тусгай сангийн хөрөнгөөс санхүүжилтийг дараах журмаар гүйцэтгэнэ:

29.1.1. энэ хуулийн 5.4.1, 5.4.2, 5.4.4-5.4.6, 5.4.8, 5.4.12-5.4.14, 5.4.16, 5.4.17, 5.4.20, 5.4.21-д заасан тусгай сангийн хөрөнгөөр

хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг мөн хуулийн 26.3-т заасан этгээдийн шийдвэрээр;

29.1.2. энэ хуулийн 5.4.3, 5.4.9, 5.4.19-д заасан тусгай сангийн хөрөнгөөс хийх санхүүжилтийг мөн хуулийн 26.6-д зааснаар батлагдсан журмын дагуу;

29.1.3. энэ хуулийн 5.4.22-т заасан тусгай сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг мөн хуулийн 26.4-т заасан этгээдийн шийдвэрээр.

29.2. Энэ хуулийн 5.4.7-д заасан тусгай сангаас хөрөнгө зарцуулах тухай Засгийн газрын шийдвэрийг дараах журмаар хэрэгжүүлнэ:

29.2.1. санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь уг арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дансанд шилжүүлэх;

29.2.2. төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагын дансанд шилжүүлэх;

29.2.3. энэ хуулийн 28.2.1-д заасан хэлбэрээр санхүүжилт хийсэн бол төсвийн ерөнхийлөн захирагч нь гүйцэтгэгч байгууллагын урьдчилгаагаар авсан хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын тайланг хянаж, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараагийн шатны санхүүжилтийг авах хүсэлт гаргах.

29.3. Төрийн сангийн газар нь Засгийн газрын нөөц сангаас олгох санхүүжилтийг тухайн төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээг хэрэгжүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний харилцах дансанд шууд шилжүүлэхийг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Тусгай сангийн гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих журам

30 дугаар зүйл. Тусгай сангийн тайлан

30.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 39.2-т заасан тайланд тусган санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

30.2. Энэ хуулийн 5.4.22-т заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээд нь энэ хуулийн 30.1-д заасан журмыг нэгэн адил баримтална.

30.3. Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл, арга

хэмжээний гүйцэтгэгч нь хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаж, тогтоосон хугацаанд төсвийн ерөнхийлөн захиргагчид хүргүүлнэ.

30.4. Тусгай сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай¹ хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

30.5. Засгийн газрын нөөц сан, Эрсдэлийн сан, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн зарцуулалтын тайланг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37.2-т заасан тайланд тусгаж Засгийн газар болон Улсын Их Хуралд тайлагнана.

30.6. Тусгай сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор өдөр тутмын хэвлэлд нийтэлж нийтэд мэдээлнэ.

30.7. Олон улсын гэрээний дагуу байгуулагдсан тусгай сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг хандивлагч талд өгөхийн зэрэгцээ түүнд аудит хийх боломж олгоно.

31 дүгээр зүйл. Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих

31.1. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ.

31.2. Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг хэлэлцэж болно.

31.3. Засгийн газрын нөөц сан, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын явцад санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

31.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр тухайн салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.

31.5. Засгийн газрын нөөц сан, Эрсдэлийн сан, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдал төрийн аудитын байгууллага хуульд заасан журмын дагуу аудит хийх эрхтэй.

31.6. Энэ хуулийн 5.4.22-т заасан тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад олон улсын гэрээ болон энэ хуулийн дагуу хяналт тавина.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

32 дугаар зүйл. Тусгай сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл

32.1. Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

32.2. Олон улсын гэрээнд тухайн сангийн дансыг арилжааны банкинд байршуулахаар зааснаас бусад тохиолдолд тусгай сангийн дансыг төрийн сангаас гадуур байршуулахыг хориглоно.

33 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

33.1. Энэ хуулийн 32 дугаар зүйлд заасныг зөрчсөн, эсхүл тусгай сангийн хөрөнгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр ашигласан, зарцуулсан, санхүүжилтийг өөр байгууллагад олгосон албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан 40000-60000 хүртэл төгрөгөөр торгоно.

33.2. Эрх бүхий улсын байцаагч энэ хуулийн 30.3-т заасныг зөрчсөн хуулийн этгээдийг 200000 төгрөгөөр, албан тушаалтныг 50000 төгрөгөөр тус тус торгоно.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

¹ Төрийн аудитын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 10 дахь заалт нэмсүгэй:

"5.1.10. тариаланг дэмжих, хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх".

2 дугаар зүйл. Тариалангийн тухай хуулийн 13.2-ын "дэмжих сангийн хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ" гэснийг "хөгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ", 13 дугаар зүйлийн нэрийн "дэмжих сан" гэснийг "хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх", 13.3-ын "Тариаланг дэмжих сангийн" гэснийг "Энэ хуулийн

13.2-т заасан", 17.1.2-ийн "Тариаланг дэмжих сангаас" гэснийг "төрөөс" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Тариалангийн тухай хуулийн 4.1.3, 5.1.6 дахь заалт, 13.1 дэх хэсэг, 13.2.3, 13.3.6 дахь заалт, 13.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дархлаажуулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"19 дүгээр зүйл. Дархлаажуулалтын үйл ажиллагааг төрөөс дэмжих

19.1. Дархлаажуулалтын зориулалтаар урьдчилан сэргийлэх тарилга хийх, эм, бэлдмэл, зүү, тариур бэлтгэх зэрэг урьдчилан сэргийлэх үйл

ажиллагааг санхүүжүүлэхэд улсын төсвөөс дэмжлэг үзүүлнэ."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын татварын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин

төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх заалт, 22 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон сууцны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмсүгэй:

"8.2.4. орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх."

нэрийн "сангийн орлогын эх үүсвэр" гэснийг "үйл ажиллагааг санхүүжүүлэх", 11.1-ийн "сангийн орлого дараахь эх үүсвэрээс бүрдэнэ" гэснийг "үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ", 11.1.3-ын "иргэнээс орон сууц хөгжүүлэх санд оруулсан" гэснийг "иргэний" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Орон сууцны тухай хуулийн 3.1.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.1.3. "орон сууц хөгжүүлэх үйл ажиллагаа" гэж орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, түүний дэд бүтцийг сайжруулах, хөгжүүлэх арга хэмжээг";

4 дүгээр зүйл. Орон сууцны тухай хуулийн 11.1.1-ийн "орон сууц хөгжүүлэх санд" гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Орон сууцны тухай хуулийн 10 дугаар зүйл, 11.1.2 дахь заалт, 12, 13 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Орон сууцны тухай хуулийн 1.1-ийн "сан, түүнийг захиран зарцуулах" гэснийг "үйл ажиллагааг санхүүжүүлэх", 7.1.3-ын "улсын сангийн үйл ажиллагааг зохицуулан удирдаж" гэснийг "үйл ажиллагааг санхүүжүүлэх", 8.1.3-ын "орон нутгийн санд" гэснийг "үйл ажиллагаанд", Дөрөвдүгээр бүлгийн нэрийн "сан" гэснийг "үйл ажиллагааг санхүүжүүлэх", 11 дүгээр зүйлийн

6 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7, 18 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараахь заалт, хэсэг нэмсүгэй:

хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдалтай танилцах, үр дүнд нь хянан магадлагаа хийлгэх, үнэлгээ, дүгнэлт гаргуулах, шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн шийдвэр гарах хүртэл санхүүжилтийг түр зогсоох;

1/7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8, 9, 10, 11 дэх заалт:

"7.1.8. улсын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын

7.1.9. шинжлэх ухаан, технологийн мэдээлэл авах, эрдэм шинжилгээний хурал,

мөзлөгөөн, семинар зохион байгуулах, мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээг санхүүжүүлэх;

7.1.10. шинжлэх ухаан, технологийн төслийн зардал, хөрөнгө оруулалтыг хуваарилах талаар санал гаргах;

7.1.11. эрдэм шинжилгээний байгууллагад эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх, түүний үр дүнг ашиглахад зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжилт хийх, олгосон хөрөнгийг эргэж төлүүлэх талаар арга хэмжээ авах.”.

2/ 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“18.2. Улсын захиалгатай шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам, онолын суурь судалгааны жагсаалтыг Засгийн газар батална”.

2 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн нэрийн “санхүүжүүлэх” гэсний дараа “журам” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8.3.4-ийн “шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр” гэснийг “улсын төсвийн хөрөнгөөр”, 10.1.1-ийн “шинжлэх ухаан,

технологийн сан” гэснийг “Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага”, 17 дугаар зүйлийн “Сангийн хөрөнгө” гэснийг “улсын болон”, 18.1.2-ын “Сангийн” гэснийг “улсын төсвийн”, 22.1-ийн “Сангийн” гэснийг “Улсын”, 22.5-ын “Сангийн” гэснийг “улсын төсвийн” гэж, 23.2.2-ын “Сангаас” гэснийг “Улсын төсвөөс”, 7.1.8, 7.1.9 дэх заалтын дугаарыг “7.1.12, 7.1.13” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22.3 дахь хэсгийн “баталсан төслийг санхүүжүүлэх Сан”, мөн заалтын “тус тус” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11, 19, 20, 21 дүгээр зүйл, 23.2.1, 23.2.5 дахь заалт, 23.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 8.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 12 дахь заалт нэмсүгэй:

“8.1.12. тухайн жилд хэрэгжүүлэх бүсийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг баталж, санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх”.

2 дугаар зүйл. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 16.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин

төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "тусгай сангийн хөрөнгө", 21 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн "болон сангийн" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 11 дэх заалт нэмсүгэй:

хэсгийн "төлбөрийн 90 хувийг байгаль хамгаалах санд, 10 хувийг" гэснийг "төлбөрийг" гэж тус тус өөрчилсүгэй.

"11/ байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, экологийн боловсрол, хүмүүжил олгох ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх."

4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "шинжлэх ухаан, технологийн сангийн болон", 34 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "болон байгаль хамгаалах сан байгуулах" гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

5 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

"2.Экологийн боловсрол, хүмүүжил олгох, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх ажилд төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ."

6 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 11, 12 дахь заалтын дугаарыг "12, 13", 35 дугаар зүйлийн 3 дахь

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дипломат албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараахь заалт, хэсэг нэмсүгэй:

2/ 7 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

1/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:
"7.1.7. суугаа болон хавсран суугаа оронд нь амьдарч буй Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдэнд эд материал, санхүүгийн дэмжлэг, тусламж үзүүлэх."

"7.2 Дипломат төлөөлөгчийн газар нь энэ хуулийн 7.1.7 дахь заалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулж гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ."

7.3.Энэ хуулийн 7.1.7-д заасныг хэрэгжүүлэхийн тулд гадаадын болон дотоодын иргэд, байгууллагын хандив, тусламжийг ашиглаж болно.”.

2 дугаар зүйл. Дипломат албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийг хүчингүй болсон тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараахь заалт, хэсэг нэмсүгэй:

1/ 16 зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

“16.1.8. аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.”.

2/ 16 зүйлийн 2 дахь хэсэг:

“16.2.Энэ хуулийн 16.1.8-д заасан үйл ажиллагааг гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаадын болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж, хуулиар

хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.”.

2 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 16.1.8-16.1.14 дэх заалтын дугаарыг “16.1.9-16.1.15” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 14.1.4 дэх заалт, Тавдугаар бүлгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 14 дэх заалт нэмсүгэй:

“28.1.14. суралцагчид хөнгөлөлттэй зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх, сургалтын төлбөрийг төр хариуцах асуудлыг Засгийн газраас баталсан журмын дагуу шийдвэрлэх.”.

2 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“39.7. Суралцагчид хөнгөлөлттэй зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэхэд улсын төсвөөс дэмжлэг үзүүлж болно.”.

3 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн 28.1.14 дэх заалтын дугаарыг “28.1.15” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар
сарын 8-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГО УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Эрүүгийн хууль², энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "мөнгө угаах" гэж хууль бусаар олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж уг эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулахыг;

3.1.2. "терроризмыг санхүүжүүлэх" гэж террорист байгууллага болон террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж аливаа хэлбэрээр эд хөрөнгө хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулахыг;

3.1.3. "мэдээлэх үүрэгтэй этгээд" гэж энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан этгээдийг;

3.1.4. "хууль бусаар олсон эд хөрөнгө" гэж Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг;

3.1.5. "сэжигтэй гүйлгээ" гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн,

түүнчлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзэж байгаа гүйлгээг;

3.1.6. "бэлэн мөнгөний гүйлгээ" гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглан хийсэн гүйлгээг;

3.1.7. "гүйлгээг түдгэлзүүлэх" гэж сэжигтэй гүйлгээний талаархи мэдээллийг салгах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан шийдвэрийн дагуу тухайн гүйлгээг түр зогсоохыг.

3.2. Энэ хуулийн 3.1.5-д заасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсын жагсаалтыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

4 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээд

4.1. Дараахь этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй:

4.1.1. банк;

4.1.2. банк бус санхүүгийн байгууллага;

4.1.3. даатгалын компани;

4.1.4. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;

4.1.5. барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг этгээд;

4.1.6. хадгаламж, зээлийн хоршоо;

4.1.7. валют худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхэлдэг этгээд;

4.1.8. төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг этгээд.

4.2. Энэ хуулийн 4.1-д заагаагүй бусад хуулийн этгээд, иргэн тодорхой гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзсэн, эсхүл 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний

¹ Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

² Эрүүгийн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн

талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлж болно.

4.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр данс нээх, гүйлгээ хийх, хаагдсан данс ашиглахыг хориглоно.

5 дугаар зүйл. Харилцагчийн талаархи мэдээллийг шалгах

5.1. Дараахь тохиолдолд энэ хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийн талаархи мэдээллийг шалгах үүрэгтэй:

5.1.1. санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө;

5.1.2. 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;

5.1.3. хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь энэ хуулийн 5.1.2-т заасан хэмжээнээс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бөгөөд энэхүү гүйлгээ нь энэ хуулийн 5.2-т заасан мэдээллийг гаргаж өгөхөөс зайлсхийх зорилго агуулсан гэж үзэх үндэслэл байгаа бол;

5.1.4. харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах шаардлагатай бол;

5.1.5. гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийхийн өмнө;

5.1.6. тухайн харилцагчийг буюу гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх бусад үндэслэл байгаа бол.

5.2. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд дараахь мэдээллийг харилцагчаасаа гаргуулж авна:

5.2.1. харилцагч нь иргэн бол түүний эцэг /эх/-ийн нэр, нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

5.2.2. харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаархи дэлгэрэнгүй танилцуулга;

5.2.3. тухайн гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээлэл;

5.2.4. бэлэн бус шилжүүлэг хийлгэсэн этгээдийн тухай мэдээлэл.

5.3. Харилцагч этгээд энэ хуулийн 5.2-т заасан мэдээллийг өгөхөөс татгалзвал энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь данс нээх, гүйлгээ хийх,

санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

5.4. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ хуулийг батлагдахаас өмнө санхүүгийн харилцаа тогтоосон бүх харилцагчийн талаархи мэдээллийг энэ хуулийн 5.2-т заасан шаардлагад нийцүүлэн 1 жилийн дотор шинэчилнэ.

6 дугаар зүйл. Тусгайлан хянах гүйлгээ

6.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь дараахь гүйлгээг тусгайлан хянах үүрэгтэй:

6.1.1. 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ;

6.1.2. тухайн гүйлгээний утга нь тодорхой бус;

6.1.3. энэ хуулийн 3.2-т заасан жагсаалтад орсон улсаар дамжуулан хийсэн гүйлгээ;

6.1.4. бэлэн бус шилжүүлэг хийсэн, эсхүл шилжүүлэг хийлгэсэн этгээдийн тухай бүрэн мэдээлэлгүй;

6.1.5. энэ хуулийн 3.2-т заасан жагсаалтад орсон улсын төрийн албан тушаалтан болон улс төрийн намын удирдлагын нэр дээр хийгдэх гүйлгээ;

6.1.6. тухайн харилцагчийн урьд нь хийж байснаас өөр бөгөөд утга нь тодорхойгүй гүйлгээ.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан гүйлгээний талаар энэ хуулийн 4.1-д заасан этгээд нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах зэргээр бололцоотой бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

7 дугаар зүйл. Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэх

7.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь энэ хуулийн 5.1.2, 5.1.3, 5.1.5-д заасан бэлэн мөнгөний гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.

7.2. Энэ хуулийн 7.1-д заасан гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор, хэрэв тухайн гүйлгээ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан гэж үзэх үндэслэл байгаа бол 24 цагийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд батлагдсан маягтын дагуу холбогдох мэдээллийг баримтын хамтаар хургуулна.

7.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд мэдээллийг факс, цахим хэлбэрээр, эсхүл бичгээр Санхүүгийн мэдээлэх албанд хүргүүлэх бөгөөд хэрэв утсаар хүргэсэн бол түүнийгээ нэн даруй факс буюу бичгээр баталгаажуулна.

7.4. Эрх бүхий байгууллага бичгээр хүсэлт ирүүлсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь Монгол банкны Ерөнхийлөгч, Улсын ерөнхий прокурорын хамтран баталсан мэдээлэл өгөх журмын дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг гаргаж өгнө.

8 дугаар зүйл. Харилцагчийн талаархи баримт, материалыг хадгалах

8.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь харилцагчтай хийсэн гүйлгээ болон хаагдсан данс, тэдгээртэй холбогдох баримт бичгийг 5-аас доошгүй жил хадгална.

9 дүгээр зүйл. Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл

9.1. Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл дараахь агуулгатай байна:

9.1.1. энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн нэр, хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /гэх/-ийн нэр, нэр;

9.1.2. харилцагч, эцсийн хүлээн авагчийн талаархи мэдээлэл;

9.1.3. тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, огноо, дансны дугаар, гүйлгээнд оролцогчид болон данс эзэмшигчийн талаархи мэдээлэл;

9.1.4. тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;

9.1.5. холбогдох бусад баримт бичиг.

10 дугаар зүйл. Дансанд хяналт тавих

10.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс хүлээн авсан мэдээлэлд дурдсан дансыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглаж байгаа гэж үзэх үндэслэл байгаа бол Санхүүгийн мэдээллийн алба тухайн дансанд хяналт тавьж болно.

11 дүгээр зүйл. Гүйлгээг түдгэлзүүлэх

11.1. Харилцагчийн хийсэн буюу хийлгүүлэх гэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэл байгаа бол Санхүүгийн мэдээллийн алба тухайн гүйлгээг түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно.

11.2. Энэ хуулийн 11.1-д заасан шийдвэрийг мөн хуулийн 4.1-д заасан этгээдэд бичгээр, тийм боломжгүй бол утсаар мэдэгдэж шийдвэрийг 24 цагийн дотор хүргүүлнэ.

11.3. Гүйлгээг түдгэлзүүлэх хугацаа ажлын 3 өдрөөс хэтрэхгүй бөгөөд энэ хугацаанд Санхүүгийн мэдээллийн алба дараахь арга хэмжээ авна:

11.3.1. тухайн гүйлгээний талаар дотоод, гадаадын холбогдох байгууллагаас шаардлагатай мэдээлэл цуглуулах;

11.3.2. тухайн гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан гэж үзэх баримт, үндэслэл тогтоогдсон бол энэ тухай эрх бүхий байгууллагад мэдэгдэж холбогдох баримт бичгийг шилжүүлэн шалгуулах;

11.3.3. тухайн гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан гэдэг нь тогтоогдвол гүйлгээг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг цуцалж энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд нэн даруй мэдэгдэх.

12 дугаар зүйл. Хариуцлагаас чөлөөлөх

12.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг банкны болон мэргэжлийн нууц задруулсан гэж үзэхгүй.

12.2. Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан нь тогтоогдсон ч тухайн мэдээлэл өгсөн этгээдийг захиргааны болон эрүүгийн хариуцлагад татахыг хориглоно.

12.3. Тодорхой гүйлгээг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь энэ хуулийн 4.1-д заасан этгээд болон Санхүүгийн мэдээллийн албыг хариуцлагад татах үндэслэл болохгүй.

12.4. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд болон Санхүүгийн мэдээллийн албаны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан бол хохирлыг Иргэний хуульд³ заасны дагуу шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

13.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд болон Санхүүгийн мэдээллийн алба нь энэ хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд харилцагчийн гүйлгээний тухай мэдээлэл өгөх, дамжуулахыг хориглоно.

13.2. Санхүүгийн мэдээллийн албаны дарга, хянан шалгагч албан үүргийнхээ дагуу олж авсан харилцагчийн гүйлгээтэй холбогдсон мэдээллийн нууцлалыг бүрэн эрхийн хугацаанд болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулахыг хориглоно.

³ Иргэний хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийлэгдсэн

14 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт

14.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр баталж мөрдүүлэх бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

14.1.1. сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх журам;

14.1.2. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 14.1.1-д заасан журмын хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;

14.1.3. энэ хуулийн 14.1.2-т заасан ажилтыг мэргэшүүлэх сургалтад хамруулах.

14.2. Энэ хуулийн 14.1-д заасан хөтөлбөрийг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлж бүртгүүлнэ.

14.3. Энэ хуулийн 14.1-д заасан журмын үлгэрчилсэн загварыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

15 дугаар зүйл. Монгол Улсын хилээр бэлэн мөнгө оруулах, гаргах

15.1. Зорчигч 5 саяас 20 сая хүртэл төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютыг Монгол Улсын хилээр бэлнээр оруулах, гаргах бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ.

15.2. Энэ хуулийн 15.1-д зааснаас их хэмжээ /20.0 саяас дээш/-ний бэлэн мөнгийг Монгол Улсын хилээр оруулах буюу гаргах бол энэ тухай Санхүүгийн мэдээллийн албаны итгэмжлэгдсэн төлөөлөгчид батлагдсан мэдүүлгийн дагуу мэдүүлнэ.

15.3. Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан мэдүүлэг гаргахаас зайлсхийсэн, татгалзсан, эсхүл худал мэдүүлсэн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

15.4. Энэ хуулийн 15.2-т заасан мэдүүлгийн маягтын загварыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Санхүүгийн мэдээллийн алба

16 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн алба

16.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг

хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн алба Монголбанкны бүтцэд ажиллана.

16.2. Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

16.3. Санхүүгийн мэдээллийн албаны даргыг Сангийн сайдтай зөвшилцөн Монголбанкны Ерөнхийлөгч томилно.

16.4. Санхүүгийн мэдээллийн албаны дарга, хянан шалгагч дараахь шалгуурыг хангасан байна:

16.4.1. банк, санхүү, хууль зүйн салбарт 3-аас доошгүй жил ажилласан;

16.4.2. эзэлийн болон баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

16.4.3. ял шийтгэлгүй.

17 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн албаны чиг үүрэг

17.1. Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 10, 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.1. энэ хуулийн 4.1, 4.2-т заасан этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх;

17.1.2. эрх бүхий байгууллагад шилжүүлсэн сэжигтэй болон бэлэн мөнгийн гүйлгээний мэдээллийн сан бүрдүүлэх;

17.1.3. сэжигтэй болон бэлэн мөнгийн гүйлгээний талаар ирүүлсэн мэдээллийн дагуу авсан арга хэмжээний талаар энэ хуулийн 4.1-д заасан этгээд болон төрийн эрх бүхий байгууллагад тогтмол мэдээлэх;

17.1.4. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

17.1.5. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл, сурталчилгаа явуулах.

17.2. Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгагч мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж; хууль тогтоомжийн зөрчил арилгахыг энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс шаардах, эсхүл эрх бүхий байгууллагад шилжүүлж шалгуулах буюу тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох санал боловсруулах эрхтэй.

17.3. Санхүүгийн мэдээллийн алба нь энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний албан тушаалтан энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавина.

18 дугаар зүйл. Мэдээллийн сан

18.1. Санхүүгийн мэдээллийн алба нь энэ хуульд заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сантай байна.

18.2. Мэдээллийн санд мэдээлэл хадгалах, түүнийг ашиглах журмыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

19 дүгээр зүйл. Гадаад улсын ижил төстэй байгууллагатай харилцах

19.1. Санхүүгийн мэдээллийн алба нь ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, нууцлалын байдлаар ижил түвшиний гадаад улсын болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

19.2. Санхүүгийн мэдээллийн алба нь энэ хуулийн 19.1-д заасан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн тэдгээрт шаардлагатай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгч болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

20 дугаар зүйл. Хамтын ажиллагааны Зөвлөл

20.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд Ажиллах Монголбанкны Ерөнхийлөгч батална.

21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

21.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Санхүүгийн мэдээллийн албаны хянан шалгалч гэм буруутай этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

21.1.1. энэ хуулийн 4.3, 5.3-т заасныг зөрчсөн албан тушаалтныг 250000 хүртэл, хуулийн этгээдийг 1000000 хүртэл төгрөгөөр торгох;

21.1.2. энэ хуулийн 13 дугаар зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтныг 500000 хүртэл, хуулийн этгээдийг 1000000 хүртэл төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн гарчигийн "Мөнгө угаах, алан хядах ажиллагааны эсрэг" гэснийг "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх" гэж, 36.1-ийн "Мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй" гэснийг "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 34, 35 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд дор дурдсан агуулгатай 3¹ дугаар зүйл нэмсүгэй:

1/ "3¹ дугаар зүйл. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүний хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ

Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүний хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн хэмжээ нь Нийгмийн даатгалын сангаас

олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тогтоосон бүрэн тэтгэврийн доод хэмжээтэй тэнцүү байна."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот**ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 5' дугаар зүйл:

"5' дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан нэгжийн чиг үүрэг

5'.1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан даатгалын байгууллага нь эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалын үйл ажиллагаа эрхлэх нэгжтэй байж болох бөгөөд тэрбээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5'.1.1. эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

5'.1.2. эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэх, орлого зарлагын гүйцэтгэлийг хангах, үйл ажиллагаагаа даатгалын зөвлөлд тайлагнах;

5'.1.3. эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагатай даатгалын гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавьж, дүгнэх;

5'.1.4. өвчин, эмгэгийн оношлогоо, эмчилгээний удирдамжийн дагуу даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих;

5'.1.5. эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх;

5'.1.6. эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар санал боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

5'.2. Энэ зүйлийн 5'.1 дэх хэсэгт заасан нэгж нь чиг үүргийг нь хэрэгжүүлэх эрүүл мэндийн даатгалын байцаагчтай байж болох бөгөөд тэрбээр Нийгмийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан эрх эдэлж, хариуцлага хүлээнэ. "

2/ 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн

4 дэх заалт, 3, 4 дэх хэсэг:

"9.2.4. энэ хуулийн 5.4, 7.8, 9.3, 9.4, 12.14. дэх хэсэгт тус тус заасан зардал."

"9.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн 10 хувьтай тэнцэх хөрөнгийг болзошгүй эрсдэлийн нөхцөлд үлдэж бслэх бөгөөд түүнийг зарцуулах журмыг нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

9.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн хэмнэгдсэн үлдэгдлийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэрийг үндэслэн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, тэдгээрийн хүртээмж, хамралтыг нэмэгдүүлэхэд зарцуулж болно. "

3/10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"10.1. Даатгалын байгууллага даатгуулагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагатай даатгалын гэрээ байгуулна."

4/ 12 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:

"12.14. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэн олгож болох бөгөөд журмыг нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална."

5/15 дугаар зүйлийн 6, 7 дахь

хэсэг:

"15.6. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8.2.2, 8.2.3, 8.2.5-д заасан үүргээ биелүүлээгүй бол энэ хуулийн 5' дугаар зүйлийн 5'.2. дахь хэсэгт заасан эрүүл мэндийн даатгалын байцаагч шимтгэлийг нөхөн төлүүлж, буруутай албан тушаалтныг 10000-50000, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр тус тус торгох шийтгэл ногдуулна.

15.7. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй иргэнээр төлөөгүй хугацааны даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлнэ."

2 дугаар зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1-ийн "шимтгэлийн хувь хэмжээг" гэсний дараа "даатгалын зөвлөлийн саналыг үндэслэн" гэж, 8.2.3-ын "6.1.8-д" гэсний дараа "6.1.11" гэж, 12.2-ын "гүйцэтгэлээр" гэсний дараа "дараа сарын 25-ны дотор" гэж, 12.9-ийн "заасан" гэсний дараа "хөнгөлөлттэй олгох" гэж, 15.4-ийн "төлбөрийг" гэсний дараа "14-өөс дээш хоногоор" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 5 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"5.3. Даатгалын зөвлөл нь дараахь бүрэлдэхүүнтэй байна."

"5.4. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан даатгалын зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, даатгалын зөвлөлийн ажиллах журмыг талуудын саналыг үндэслэн батална. Даатгалын зөвлөлийн дарга, гишүүдэд ажлын оролцоог харгалзан урамшуулал олгож болно."

2/7 дугаар зүйл:

"7 дугаар зүйл. Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

7.1. Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд дараахь тусламж үйлчилгээ хамаарна:

7.1.1. дотрын өвчний;

7.1.2. мэдрэлийн тогтолцооны

өвчний;

7.1.3. нүд, чих, арьс ба халимын, яс, булчин, холбох нэхдэсийн өвчний;

7.1.4. яаралтай бус гэмтэл, мэс заслын өвчний.

7.2. Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу тухайн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллага үзүүлэх бөгөөд төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлаас давсан, эсхүл өндөр технологи бүхий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

7.3. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн байгууллагыг сонгох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

7.4. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний жагсаалт болон тэдгээрийг санхүүжүүлэх төлбөрийн аргыг хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

7.5. Даатгуулагч аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ авах тохиолдолд харьяалал харгалзахгүй үйлчлүүлнэ.

7.6. Өрх, сум, багийн эмнэлэгт бүртгэлтэй даатгуулагч өрх /сум, баг/-ийн эмчийн жороор зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад заасан эмийг эмийн сангаас худалдан авах тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлнэ.

7.7. Эрүүл мэндийн байгууллага даатгалгүй иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тохиолдолд түүнээс энэ хуулийн 7 дугаар зүйлийн

7.1. дэх хэсэгт заасан тусламж, үйлчилгээний бодит өртөгөөр тооцсон хэмжээгээр төлбөр авна.

7.8. Дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулж урамшуулах бөгөөд журмыг нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

3/12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"12.6. Даатгуулагч энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, түүнчлэн даатгуулсан эсэхээс үл хамааран төрөөс төлбөрийг нь хариуцахаар холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг өөрөө хариуцна."

4 дүгээр зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.1 дэх хэсгийн "даатгуулагчийн амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх" гэснийг "эрүүл мэндийн даатгалын" гэж, 8.1.3-ын "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс" гэснийг "Засгийн газраас" гэж, 9.2.1-ийн "амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх" гэснийг "эрүүл мэндийн даатгалын" гэж, 11.1 дэх хэсгийн "даатгалын гэрээ байгуулсан" гэснийг "даатгагч" гэж, 11.3 дахь хэсгийн "даатгалын гэрээнд заасны дагуу хураамж" гэснийг "шимтгэл" гэж, 12.9 дэх хэсгийн "12.8" гэснийг "7.6" гэж, 12.11 дэх хэсгийн "амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх" гэснийг "эрүүл мэндийн даатгалын" гэж, 14.1 дэх хэсгийн "үр дүн" гэснийг "үр дүнд" гэж, "10.1" гэсэн хэсгийн дугаарыг "10.2" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.2.3-ын "6.1.1, 6.1.2-т хамаарахаас бусад", 10.1 дэх хэсгийн "даатгалын шимтгэл, түүнийг төлөх хугацаа", 12.1 дэх хэсгийн "амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх", 12.2 дахь хэсгийн "амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх", мөн хэсгийн "хувьсах", 12.5 дахь хэсгийн "5 хувийг анхан шатны эмнэлэгт", 12.11 дэх хэсгийн "Энэ хуулийн 6.1-д заасан", 14.1 дэх хэсгийн "даатгалын үйл ажиллагаанд" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10.2 дахь хэсэг, 12.3, 12.4, 12.7, 12.8, 12.10 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2006 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр байгуулсан "Санхүүгийн зохицуулалт ба засаглалын хөтөлбөр"-ийн зээлийн хэлэлцээрийг Монгол

Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"39.1.1.улсын бүртгэгч энэ хуульд заасан журмыг зөрчиж эрхийн бүртгэл хийсэн, бүртгэлийн мэдээллийг задруулсан, эсхүл хууль зүйн үндэслэлгүйгээр бүртгэл хийхээс татгалзсан бол түүнд ерөнхий бүртгэгч, ерөнхий бүртгэгч энэхүү зөрчлийг гаргасан бол эрхэлсэн сайдын шийдвэрээр хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл ногдуулах;"

2 дугаар зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.5, 6.6, 10.1, 11.1, 15.1, 21.3, 24.8, 28.1, 29.4, 30.2, 30.3, 31.2, 32.3, 33.3, 34.2, 35.2, 36.2, 37.1 дэх хэсэг, Хоёрдугаар бүлгийн болон 10 дугаар зүйлийн гарчгийн "алба" гэснийг "асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага" гэж, 8.1 дэх хэсгийн "алба"

гэснийг "төрийн захиргааны байгууллага" гэж, 7.5, 13.1, 21.2, 24.9, 29.3 дахь хэсгийн "албанд" гэснийг "төрийн захиргааны байгууллагад" гэж; 7.8, 37 дугаар зүйлийн гарчгийн "албанаас" гэснийг "асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас" гэж; 10.2, 11 дүгээр зүйлийн гарчиг, 14.1.2 дахь хэсгийн "албаны" гэснийг "асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын" гэж; 10.5, 18.3 дахь хэсгийн "улсын ерөнхий бүртгэгч" гэснийг "эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" гэж; 12.7, 15.6 дахь хэсгийн "төрийн захиргааны байгууллагын дарга" гэснийг "Засгийн газрын гишүүн" гэж; 15.5 дахь хэсгийн "төрийн захиргааны байгууллагын даргад" гэснийг "Засгийн газрын гишүүнд" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-ын "алба" гэснийг "асуудал

эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 6 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

Хуулийн байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай Хүний эрхийн Үндэсний Комиссын 2006 оны илтгэл, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий прокурорын мэдээллийг тус тус хэлэлцээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 45.7 дүг хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хуулийн байгууллагуудын хараат бус ажиллах баталгааг сайжруулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөөс сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасгай:

1/ нийгмийн хор аюул багатай эрүүгийн хэргийг байцаан шийтгэх ажиллагааг хялбаршуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад гарч байгаа зарим хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, цагдан хорих үндэслэлийг тодорхой болгох, хугацааг богиносгох, эрүүдэн шүүхийн эсрэг олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх чиглэлээр Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/ эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх, гэмт хэргийн дүн мэдээ, шалтгаан, эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор эрүүгийн гэмт хэргийн дүн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох;

3/ төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогын хүрээнд шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдыг 2006-2016 онд орон сууцаар бүрэн хангах хөтөлбөр боловсруулж, эхний ээлжинд хөдөө орон нутагт томилогдон ажиллаж зочид буудал болон хувь хүнээс орон сууцны өрөө, байр түрээслэн амьдарч байгаа шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэргийн төлөөлөгч нарыг гэр, орон сууцтай болгох арга хэмжээг нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, 2007 оноос орон сууц худалдан авах зардлыг тухайн байгууллагын төсөвт тусган, орон сууцыг урт хугацааны зээлээр олгож эхлэх;

4/ Өвөрхангай, Увс, Ховд аймгийн цагдаагийн хэлтсийг газар болгон зохион байгуулсантай холбогдон 2006 оны сүүлийн хагас жилд нэмж шаардагдах 200 сая төгрөгийг

шийдвэрлэх, энэ тогтоолын хавсралтад заасан арга хэмжээнд шаардагдах зардлыг Монгол Улсын 2007 оны улсын төсөвт тусган хэрэгжүүлэх.

2. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай 2006 оны илтгэл, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи мэдээлэл, Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанд гишүүдээс гаргасан санал, дүгнэлтийн мөрөөр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч /С.Батдалгэр/, Улсын ерөнхий прокурор /М.Алтанхуяг/ нарт зөвлөж, Хууль зүй, дотоод хэргийн сайд /Д.Одбаяр/-д үүрэг болгосугай.

1/ цагдан хорих байранд хоригдож байгаа этгээдэд хэрэг хүлээлгэх, мэдүүлэг авах зорилгоор сэтгэл санаа, бие махбодид нь дарамт, гэмтэл учруулах, өрөө дамжуулан хорих зэргээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа байдалд дүгнэлт хийж, зөрчлийг арилгуулан, зөрчил гаргасан төрийн албан хаагчид хариуцлага тооцож ажиллах;

2/ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хууль ёсыг сахих, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хүний халдашгүй байх эрхийг хангах, хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох зарчмыг шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаанд бүрэн төлөвшүүлэх;

3/ сэжигтнийг баривчлах, цагдан хорих ажиллагаа нь хуульд заасан үндэслэл, хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэхэд тавих прокурорын хяналтыг сайжруулах;

4/ хүний эрхийг хамгаалах чиглэлээр Хүний эрхийн Үндэсний Комисс, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах.

3. Шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн байгууллагуудын ажилтны цалин хангамж, нийгмийн асуудлыг судлан санал боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллуулж, дүнг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Хууль зүйн байнгын орлого /Ц.Мөнх-Оргил/-нд даалгасгай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ



Улсын Их Хурлын 2006 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 54 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН 2007 ОНЫ УЛСЫН ТӨСӨВТ ТУСГАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

1. Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн криминалистикийн болон шүүх эмнэлгийн шинжилгээний техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, иргэдийн гарын хээний нэгдсэн сан бүрдүүлэхэд хэрэглэгдэх тоног төхөөрөмж авахад зориулж 2.4 тэрбум төгрөг, цагдаагийн алба хаагчдыг нийгмийн хэв журмыг сахиулах болон өндөржүүлсэн тусгай албаны зэвсэг, техник, галт зэвсэг, сум, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр хангахад эхний ээлжинд 1 тэрбум төгрөг, хэргийн газрын үзлэг явуулах тусгай зориулалтын иж бүрдэл авахад зориулж 100 сая төгрөгийг тус тус төлөвлөх;

2. Хүн ам ихээр төвлөрөн үйлдвэрлэлийн болон гар аргаар алт, бусад ашигт малтмалыг олборлож байгаа газарт цагдаагийн байнгын пост /кобон/ 10-ыг нэмж барихад 300 сая төгрөг төлөвлөх;

3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн орон тоо,

техник хэрэгслийг нэмэгдүүлэхэд 400 сая төгрөг төлөвлөх;

4. Завхан, Хөвсгөл, Орхон, Хэнтий аймгийн цагдаагийн газар, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын цагдаагийн хэлтсийн зардлын нэмэгдлийг 2007 оноос эхлэн улсын төсөвт нэмж тусгах;

5. Прокурорын төв, орон нутгийн байгууллагад компьютер, принтер, хувилагч машин авахад зориулж 131.8 сая төгрөг, эрүүгийн хэргийн төв болон салбар архивын байрыг өргөтгөх, хадгалалат, хамгаалалтын тоног төхөөрөмжөөр хангахад зориулж 65.7 сая төгрөгийг зарцуулах, архив, тоо бүртгэл, дүн шинжилгээ, мэдээллийн ажлыг нэгтгэсэн мэргэшсэн албыг бий болгох, бүтэц, орон тооны асуудлыг шийдвэрлэх;

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа зарим хорих байрыг хуульд заасан стандарт, шаардлагад нийцүүлэн өөрчлөхөд зориулж 1.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

Төслийг хууль санаачлагчид буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 21.5, 22.5-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

1. Засгийн газраас 2006 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Авто замын тухай

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 22.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул төсөл санаачлагчид нь буцаасугай.

1. Засгийн газраас 2006 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 24.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг сард 26500 төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг сард 20000 төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Энэ тогтоолыг 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" Улсын Их Хурлын 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтын

"Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд "12". Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны даргаар Дащдондовын Баярсайханыг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Байнгын хороодоос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай:

1/ Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн төсөл;

2/ "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

3/ Төрөөс мөнгөний бодлогын талаар 2007 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;



4/Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга;

5/Орон нутгийн боловсон хүчний босоо тогтолцоог зохицуулсан зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архивын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай/;

6/Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

7/Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн төсөл;

8/Нүүрс хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

9/ Бичил уурхайн тухай хуулийн төсөл;

10/Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн төсөл;

11/Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

12/Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

13/Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

14/Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

15/Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аудитын тухай

хуульд нэмэлт оруулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд;

16/Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

17/Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

18/Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

19/Хаягдал хөнгөн цагааны хайлшид нэг удаагийн татвар тогтоох тухай хуулийн төсөл, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай", "Зөвшөөрөл олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслүүд;

20/Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл; 21/ бусад.

2. Улсын Их Хурлын 2006 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэхээр төлөвлөгдөж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэхээр тогтсугай.

3.Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр энэ тогтоолд дурдаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчдаас 2006 оны 9 дүгээр сарын 15-ны дотор өргөн мэдүүлбэл намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

4.Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганы явцад өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухайн үед нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

5.Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын болтгал хангахыг Засгийн газар, Байнгын хороодын дарга нар болон Тамгын газар /Н.Луvsсанжав/-т тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 6 дугаар сарын 26–ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Дамбачүлтэмийн Байлхүүд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Төрийн албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж Монгол Улсын өмч хувьчлалын төрийн бодлогын үндсэн баримт бичгүүдийг боловсруулж тэдгээрийг хэрэгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төрийн өмчийн хорооны даргын

зөвлөх Дамбачүлтэмийн Байлхүүд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 6 дугаар сарын 26–ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Дашийн Гүрбазарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Эрчим хүчний салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж эрчим хүчний байгууллагуудын найдвартай ажиллагааг хангах, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, зах зээлийн нөхцөлд бүтэц, зохион байгуулалтыг оновчтой зөв шийдвэрлүүлэх, тус салбарыг мэргэжлийн удирдлагаар хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дархан-Уул

аймгийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, эрчим хүч, инженерийн шугам сүлжээ хариуцсан мэргэжилтэн Дашийн Гүрбазарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 6 дугаар сарын 26–ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Дэмбэрэлийн Амгаланд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж орон нутгийн боловсролын байгууллагуудыг чадварлаг удирдан, орчин үеийн мэдээлэл- технологийн ололтыг сургалтад нэвтрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дархан-Уул аймгийн Боловсрол соёлын

газрын дарга Дэмбэрэлийн Амгаланд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4–ний өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Дашдоржийн Цэрэнтогтоход Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол түртээх тухай

Үндэсний их баяр наадамд 4 удаа түрүүлж, 5 удаа үзүүрлэн, бөхийн чөлөөт барилдаанаар олимп, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилттай оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртэн монгол улсынхаа нэрийг алдаршуулах, үндэсний бөхийн залуу халааг бэлтгэхэд оруулж байгаа жинтэй хувь нэмрийг нь

үнэлж дархан аварга Дашдоржийн Цэрэнтогтоход Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

Начингийн Баасанжавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Эрүүл мэнд, боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж эрдэм шинжилгээний олон бүтээл туурвин эмнэлгийн нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, эмнэлгийн практикт мэс заслийн шинэ аргуудыг нэвтрүүлэн хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж П.Н.Шастины нэрэмжит III

эмнэлгийн мэс заслийн ерөнхий зөвлөх, доктор, профессор Начингийн Баасанжавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Түмэнбаярын Дашцэдэнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж эрдэм шинжилгээ, сурган хүмүүжүүлэх ухаан, Монгол бичгийг сэргээн хөгжүүлэх талаар олон арван дорвитой бүтээл туурвин залуу үеийг сурган хүмүүжүүлэх, Монгол үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт оруулж байгаа жинтэй хувь нэмрийг нь үнэлж

МУҮИС-ийн зөвлөх багш, доктор, профессор Түмэнбаярын Дашцэдэнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

Шагдарын Бирад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Шинжлэх ухааны салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгааны цогц бүтээлүүдийг туурвиж, монгол судлалыг хөгжүүлэх, судлаачдын залуу халааг бэлтгэх, монголын төр, иргэншил, соёлын түүхийг дэлхий дахинд таниулахад оруулж байгаа жинтэй хувь нэмрийг нь үнэлж академич Шагдарын

Бирад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

Чилхаажавын Авдайд Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай

Төрийн байгууллага болон боловсролын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж боловсролын шинэчлэлийн эрх зүйн орчинг бүрдүүлэх, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгон инженер техникийн мэргэжлийн боловсон хүчин, эрдэмтэд бэлтгэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж

Улсын Их Хурлын гишүүн Чилхаажавын Авдайд Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

Бирваагийн Мөнхдоржид Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж дэлхийн болон үндэсний зохиолчдын олон арван шилдэг бүтээлүүдийг тайз, дэлгэцнээ чадварлаг найруулан тавьж монголын театр, киноны урын санг баяжуулахад оруулж байгаа дорвитой хувь нэмрийг

нь үнэлж Улсын драмын эрдмийн театрын найруулагч Бирваагийн Мөнхдоржид Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 178

Улаанбаатар хот

Чинзаяатын Мөнхшүрд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Соёл урлагийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж дэлхийн болон үндэсний сонгодог дууриудад олон арван дүрийг дуулах, жүжиглэх эрдмийг хослуулан чадварлаг бүтээж, Монголын дуурийн урлагийг хөгжүүлж сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын гоцлол дуучин Чинзаяатын Мөнхшүрд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

Батболдын Энхтүвшинд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Шинжлэх ухаан, боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж Монгол улсад боловсрол судлалын нэгэн чиглэл болох боловсролын эдийн засаг, менежментийн онол, арга зүйн үндсийг тавьж хөгжүүлэх, нүүдлийн соёл иргэншлийг судлах эрдэм шинжилгээний байгууллагыг бэхжүүлэх, монгол судлалын олон улсын нэр хүндийг дээшлүүлэхэд оруулж байгаа

хувь нэмрийг нь үнэлж Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн газрын дарга Батболдын Энхтүвшинд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Галсангийн Зинаамядарт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Төрийн захиргааны байгууллагад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, манай улсад татварын албаны тогтолцоог шинээр бий болгох, зах зээлийн үеийн татварын системийг бүрдүүлэх, санхүүгийн хяналт шалгалтын болон мэргэжлийн хяналтын байгууллагыг үүсгэн байгуулж бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Улсын мэргэжлийн хяналтын газрын дэд дарга Галсангийн Зинаамядарт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

Намсрайн Ням-Осорт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсрол, соёлын салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Чингис, Их засаг судлалын талаар олон арван дорвитой бүтээл туурвиж, хувийн хэвшлийн үндэсний түүх соёлын тэрүүлэх их сургуулийг үүсгэн байгуулж, өсвөр залуу үеийг сурган хүмүүжүүлэх, манай улсын боловсролыг хөгжүүлэхэд оруулж байгаа

хувь нэмрийг нь үнэлж Чингис хааны нэрэмжит Их засаг их сургуулийн ректор Намсрайн Ням-Осорт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот

Жоосамбуугийн Одмаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Соёл урлагийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж цэрэг эх орны сэдэвт, ардын болон зохиолын дуунуудыг мэргэжлийн өндөр түвшинд дуулж уран бүтээлийнхээ санг баяжуулан, Монгол дууны урлагийг өөрийн орон төдийгүй гадаад орнуудад сурталчлахад оруулж байгаа хувь

нэмрийг нь үнэлж Цэргийн дуу, бүжгийн эрдмийн театрын гоцлол дуучин Жоосамбуугийн Одмаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

Лувсан-Очирын Дондогт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Эдийн засаг, санхүүгийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж нягтлан бодох бүртгэл, аудитын зах зээлийн үеийн шинэ тогтолцооны эрх зүйн үндсийг боловсруулж, түүнийг эзэмшсэн боловсон хүчнийг бэлтгэх, бүртгэл, аудитын удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудыг үүсгэн байгуулж төлөвшүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын ерөнхийлөгч Лувсан-Очирын Дондогт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Ишцэдэнгийн Төмөрбаат Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хилийн цэргийн анги салбар, удирдах албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж цэрэг эх орны сэдвээр олон бүтээл туурвиж, хилийн цэргийн бие бүрэлдэхүүнийг төлөвшүүлэн хөгжүүлэх, соёл урлагийн байгууллагыг бэхжүүлэх, урын санг баяжуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж хилийн цэргийн дуу бүжгийн чуулгын дарга,

хурандаа Ишцэдэнгийн Төмөрбаат Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

Даваажавын Даваанямд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл урлагийн салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр олон арван шинжлэх ухааны хялбаршуулсан баримтат кино бүтээж, тайз дэлгэцийн түүхэн кинонуудад зураглаач найруулагчаар ажилласан хувь нэмрийг нь үнэлж

Монгол кино нэгтгэлийн зураглаач, найруулагч Даваажавын Даваанямд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 186

Улаанбаатар хот

Намсрайжавын Бүтэнбаярт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж дэлхийн сонгодог болон өөрийн орны хөгжмийн зохиолчдын бүтээлүүдийг чадварлаг удирдан тоглуулж, монголын сонгодог хөгжмийн урлагийг хөгжүүлэн сурталчилахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын

филармонийн уран сайхны удирдаач Намсрайжавын Бүтэнбаярт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

Намсрайн Дамбад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Төрийн захиргаа, хөдөө аж ахуй, эдийн засгийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж Ховд аймаг болон баруун бүс нутгийн хөгжил, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, зах зээлийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Ховд аймгийн Иргэдийн

төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Намсрайн Дамбад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

Рэнчингийн Бадарчид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэн шинэ тоног төхөөрөмжөөр хангаж, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулан хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Увс аймгийн Тэс сумын хүний их эмчийн салбарын

эрхлэгч Рэнчингийн Бадарчид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

Жагваралын Бүрэнбэхэд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж тайз, дэлгэцийн олон сайхан дүр бүтээж, залуу уран бүтээлчдийг сурган хүмүүжүүлэх, удирдаачийн дэг сургуулийг төлөвшүүлэн бий болох, монголын дуурь, балет, симфонийн урлагийг хөгжүүлэх, гадаад оронд сурталчилахад оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын уран сайхны удирдаач Жагваралын Бүрэнбэхэд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Лувсангийн Бэрэнбаралд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай

Авто тээврийн салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж анхны тээврийн байгууллагыг үүсгэн байгуулж, орчин цагийн тээврийн салбар болгон хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын иргэн,

ахмад тээвэрчин Лувсангийн Бэрэнбаралд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Гочоогийн Жамцад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл-мэдээллийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж нийгэм, эдийн засаг, байгаль орчны сэдвээр олон зуун асуудал дэвшүүлсэн өгүүлэл, нийтлэл, уран зохиолын ном туурвиж, манай орны соёлын өв санд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж МОНЦАМЭ агентлагийн

Архангай аймаг дахь сурвалжлагч Гочоогийн Жамцад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

Даваажавын Нямсүрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан эрдэм шинжилгээний олон арван бүтээлүүд туурвиж, эмнэлгийн практикт эмчилгээний шинэ дэвшилтэт эргэ технологийг нэвтрүүлэн хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Улсын клиникийн төв эмнэлгийн бөөрний мэс заслын эмч Даваажавын Нямсүрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2006 оны 5 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 145 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Эрүүгийн хуулийн 7 дугаар хэсэг, 19 дүгээр бүлгийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай.

1.1. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан **"Бусдын эд хөрөнгийг хулгайлах"** гэдэгт бусдын эд хөрөнгийг нууц, далд аргаар, шунахай сэдэлтээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авч, бүр мөсөн, үнэ төлбөргүй өөрийн өмчийн адил захиран зарцуулах боломж бүрдүүлсэн буюу захиран зарцуулсан шууд санаатай үйлдлийг ойлгоно.

1.2. **"Хулгайлах"** гэмт хэргийн субъект нь 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, тухайн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхгүй Монгол Улсын иргэн, гадаад улсын харъяат, харъяалалгүй этгээд байж болно.

1.3. Бага буюу өндөр настай, сэтгэцийн болон бусад хүнд өвчтэй, согтуурсан, мансуурсан буюу унтаж байсан, хөгжлийн бэрхшээлтэй /сохор, дүлий/ зэрэг бусад байдлаас шалтгаалан тухайн үед болж байгаа үйл явдлыг мэдрэхгүй, ойлгож мэдэхгүй, илчлэх чадваргүй байдлыг далимдуулан тэдний дэргэд эд хөрөнгийг авсан үйлдлийг бусдын эд хөрөнгийг хулгайлсан гэмт хэрэг гэж үзвэл зохино.

1.4. Бусдын эд хөрөнгийг нууц, далд аргаар, шунахай сэдэлтээр авч байх үед дэргэд нь байгаа этгээд тухайн үйлдлийн шинж чанарыг ойлгож мэдээгүй, эсхүл гэмт этгээдтэй холбоотой /найз, танил, төрөл садан гэх мэт/ тул түүний зүгээс хориглох, эсэргүүцэх явдал гаргахгүй гэж тухайн этгээд тооцон бусдын эд хөрөнгийг хууль бусаар авсан үйлдлийг хулгайн гэмт хэргээр зүйлчлэх нь зүйтэй.

Харин гэмт хэрэг үйлдэх үед дэргэд нь байсан этгээд бусдын эд хөрөнгийг хууль бусаар авах үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авсан бол гэм буруутай этгээдийн үйлдлийг бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргээр зүйлчилбэл зохино.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах үед өмчлөгч буюу эзэмшигч уг үйлдлийг харсан /мэдсэн/ талаар гэмт этгээд ойлгосон атлаа авсан эд зүйлээ өөрийн эзэмшилд үлдээх зорилгоор уг үйлдлээ үргэлжлүүлсэн бол түүний үйлдлийг бусдын эд хөрөнгийг булаах, харин хохирогчийн амь биед нь аюультайгаар хүч хэрэглэсэн, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээр тус тус зүйлчилнэ.

1.5. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан **"Давтан үйлдэх"** гэдэгт хулгайн гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэн байхыг ойлгоно.

Гэхдээ гэмт хэрэг үйлдэх санаа нь тус тусдаа үүссэн, тус бүрдээ бие даасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй байх бөгөөд уг үйлдэлдээ ял шийтгүүлсэн буюу ял шийтгүүлээгүйн аль аль нь хамаарна.

Харин хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгүй болсон, ялгүйд тооцогдсон этгээдийн дахин шинээр үйлдсэн гэмт хэрэг нь давтан үйлдсэн гэмт хэрэгт тооцогдохгүй.

1.6. Мөн зүйлийн 145.2, 145.3, 145.4 дэх хэсэгт заасан **"Бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн"** гэдгийг Улсын Дээд шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 10 дугаар тогтоолд тайлбарласнаар ойлгоно.

1.7. Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан **"Машин механизм"** гэдэгт хүч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, мотоцикль, трактор, өөрөө явагч бусад машин болон өргөх, буулгах, ухах, малтах, түрэх, цоолох, зүсэх зэрэг зориулалттай машин механизмууд хамаарна.

"Машин механизмыг хэрэглэсэн" гэдгийг бусдын эд хөрөнгийг хулгайлах үйлдлээ хөнгөвчилж түргэтгэх, хамгаалалт, бэхлэлтээ эвдэх, биеэр авч чадахгүй эд хөрөнгөд хүрэх, зөөж тээвэрлэх зорилгоор урьдчилан бэлтгэж ашигласныг ойлгоно.

Харин хулгайлах үйлдэл төгссөний дараа түүнийг зөөж тээвэрлэх, хэргийн газраас зайлуулах зэрэгт машин механизм ашигласныг энэ ойлголттой хамааруулахгүй.

1.8. Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан **"тусгайлан бэлтгэсэн багаж, хэрэгсэл"** гэдэгт

хулгайн гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу ашигласан бэхлэгээ, хамгаалалтыг эвдэх зориулалт бүхий биеийн хүч нэмэгдүүлэх, үйлдлийг хялбаршуулахад хэрэглэсэн бүх төрлийн багаж хэрэгсэл, тээлж дэлбэлэх болон химийн, үйлдвэрлэлийн, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулан ойлгоно.

1.9. Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан **"орон байр"** гэдэгт хүн байнга буюу түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно. Орон байр нь хөдөлгөөнтэй, түр шинжтэй байж болно.

1.10. Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан **"агуулах сав"** гэдэг нь эд хөрөнгийг байнга буюу түр хадгалах зориулалттай байшин, пин, амбаар, илүү гэр, гэрийн болон тээврийн чингэлэг, бүх төрлийн агуулах, зоорь, автомухлаг, хөргөх ба эд бараа зөвхө төхөөрөмжтэй автомашин, граж, албан тасалгаа, үйлдвэрлэлийн эд хөрөнгийг байнга буюу түр хадгалах зориулалттай байр, түүнчлэн хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан болон тусгай зориулалтын автомашины кабин, багаж, онгоц, галт тэрэг, далайн хөлгийн ачаа хадгалах сав зэргийг хамааруулан ойлгоно.

Мал, гэрийн тэжээвэр амьтныг бусдын халдлагаас хамгаалж зориулалтын цоож, бэхлэгээ хийсэн хашаа, байр, савыг **"агуулах сав"** гэдэгт хамааруулж болно.

Харин мал болон гэрийн тэжээвэр амьтны зөвхөн өөрийнх нь хөдөлгөөнийг хорих, салхи, жавар, бороо, цаснаас нөмөрлөх зориулалтын хашаа, хороо, саравчийг энэ тайлбарын 1.10 дахь заалтын 2 дахь хэсэгт заасан шинжгүй бол "агуулах сав" гэдэг ойлголтод хамааруулахгүй.

1.11. Мөн зүйлийн 145.2 дахь хэсгийн **"орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн"** гэдгийг түлхүүр тааруулах, багаж хэрэгсэл ашиглах буюу ашиглахгүйгээр цонх, хаалга, түгжээг эвдэх, цуурыг сугалах, онгорхой байхад нь сэм орох, нуугдах зэрэг бусад аргаар нэвтрэн орохыг ойлгоно. Мөн тодорхой хугацаанд байх эрх бүхий этгээд өөр цаг хугацаанд үйлдвэрлэлийн байр, албан тасалгаа зэрэгт зөвшөөрөлгүйгээр орсон байвал орон байр, агуулах саванд нэвтэрсэн гэж үзнэ.

Харин нийтийн үйлчилгээний газар /дэлгүүр, музей, үзэсгэлэнгийн танхим гэх мэт/-т хууль ёсоор нэвтэрч орсны дараа хулгайлах гэмт хэрэг үйлдсэнийг орон байр, агуулах саванд нэвтэрсэн гэж үзэхгүй.

1.12. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2, 145.3, 145.4 дэх хэсгүүдэд заасан **"үлэмж, их, онц их хэмжээний хохирол"** гэдгийг Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар тодорхойлно.

Харин Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хувьд хохирлын хэмжээг харгалзахгүй.

1.13. Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан **"олон тооны мал хулгайлсан"** гэдэгт нэг буюу хэд хэдэн удаагийн үйлдлээр 8 бод эсхүл 25 бог, түүнээс дээш тооны мал хулгайлсан байхыг ойлгоно.

1.14. Мөн зүйлийн 145.3 дахь хэсэгт заасан **"хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан"** гэдэг ойлголт нь хулгайлсан зүйлийн хэмжээ, үнээр бус, хохирогчийн амьдралд уг зүйлийн гүйцэтгэж байсан эдийн засгийн ач холбогдлыг шалган тогтоосон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчээс өгөх үнэлэмжээр тодорхойлогдоно.

1.15. Мөн зүйлийн 145.3 дахь хэсэгт заасан **"нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж"** гэдгийг байгалийн болон ослын гамшиг тохиолдсон, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, гоц халдварт өвчин дэлгэрсэн зэрэг онцгой нөхцөл байдлын улмаас нийтийн анхаарал сарнисныг далимдуулж хулгайн гэмт хэрэг үйлдэхийг ойлгоно.

1.16. Мөн зүйлийн 145.4 дэх хэсгийн **"хулгайн гэмт хэрэгт хоёр буюу түүнээс дээш удаа, эсхүл булаах, дээрэмдэх, уулгаан довтолох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд"** гэдгийг урьд энэ төрлийн гэмт хэрэгт шүүхээр ял шийтгүүлснээс хойш Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан ялгүүд тооцох буюу ялгүй болох хугацаа өнгөрөөгүй байхыг ойлгоно.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улсын Дээд шүүхийн "Эрүүгийн хуулийн 123/ дүгээр зүйлийг тайлбарлах тухай" 1997 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 74 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР

ТАНХИМЫН ТЭРГҮҮН Д.БАТСАЙХАН

ШҮҮГЧ Ч.ГАНБАТ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265058
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 4.5